



## БУЯНТ СУМЫН ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл  
дараах хаягаар харилцана уу:

Баян-Өлгий аймаг дахь  
Төрийн аудитын газар

Тэргүүлэх аудитор  
М.Хуанган  
Утас:70422954  
Цахим хаяг:

Аудитын менежер:  
Х.Женисбек  
Утас: 70422930  
Цахим хаяг:

Аудитор: Ж.Назгүл  
Утас:99668909  
Цахим хаяг: nazka\_ali@yahoo.com

**Хаяг:** Баян-Өлгий аймаг дахь  
Төрийн аудитын газар

**Байршил:** Өлгий сум, 5-р баг,  
Аймгийн ЗДТГазрын байр, 1-р  
давхар

**Цахим хуудас:** [www.bayan-ulgii.gov.mn](http://www.bayan-ulgii.gov.mn)

2018 оны 3 дугаар сар

### Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

## АГУУЛГА

---

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар
17. Зөвлөмж
18. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

### **Нэг. Аудит хийх хууль, эрх зүйн үндэслэл**

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3, Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1 дэх заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2-т заасан аймаг дах Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Буянт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Буянт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны оны санхүүгийн нэгтгэсэн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын баталсан холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Буянт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитыг 2018 оны 3 дугаар сарын 14-нээс 3 дугаар сарын 25-ны хооронд хийхээр төлөвлөн, аймаг дах Төрийн аудитын газрын аудитор Ж.Назгүл хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Буянт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төрийн аудитын байгууллагад 2018 оны 02-р сарын 26-ны өдрийн №1/45-р албан бичгээр 3 дугаар сарын 12-нд ирүүлсэн.

Баян-Өлгий аймаг дах Төрийн аудитын газар аудитыг 2018 оны 3 дугаар сарын 26-наас 4 дугаар сарын 02-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 4 дугаар сарын 03 -нд Буянт сумын Засаг даргад гардуулна.

### **Хоёр. Байгууллагын хууль, эрх зүйн орчин**

Буянт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн захирагч нь Монгол улсын Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн албаны тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Татварын багц хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

### **Гурав. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа**

Буянт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь “Харъяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангахад оршино” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагаагаа эрхлэн гүйцэтгэж байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн удирдлага дор төсвийн шууд захирагчийг харьяалах эрх бүхий төсвийн төвлөрүүлэн захирагчтай байж болно”, 15.4-д “Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 15.4.1-д “төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-д заасны дагуу Буянт сумын Засаг дарга нь төсвийн төвлөрүүлэн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. 2017 оны төсвийг орон нутгийн төсөв, тусгай зориулалтын шилжүүлэгийн төсвийн багцаас аймгийн төрийн сангаар дамжуулан Буянт сумын төрийн сангаас олгосон байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Буянт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягад тодорхой тусгасан.

### **Дөрөв. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн**

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Буянт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын

эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 6-ийг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад тус сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг батлаагүй боловч Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан төсвийн байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэх заавар аргачлал, нягтлан бодох бүртгэлийн бодлого, арга зүйг, Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ыг мөрдөж ажилласан байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн байна.

Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа программын үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Буянт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэлгүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Буянт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан тэмдэглэл тодруулга, бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд санхүүгийн “Пластик”, “Аколоус” програм хангамж ашиглажээ.

#### **Тав. Дотоод хяналт:**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Буянт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед “бага” гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

#### **Зургаа. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:**

2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Аймгийн ТЭЗ-ийн орон нутгийн төсөв, тусгай зориулалтын шилжүүлэгийн төсвийн багцаас аймаг, сумын төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах,

төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан байна.

## 6.1. Орлого, татаас санхүүжилтийн талаар:

### 6.1.1 Улсын төсвийн санхүүжилт

Буянт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлангаар тайлант онд тусгай зориулалтын шилжүүлгээр нийтдээ 1384.5 сая төгрөгийн санхүүжилт, 10.7 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийг хүлээн авсан байна.

### 6.1.2 Орон нутгийн төсвийн санхүүжилт

Орон нутгийн захиргааны байгууллагууд аймгийн төсвөөс 277.8 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг хүлээн авч, орон нутгийн татварын орлогоос 182.7 сая төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлэн санхүүжүүлсэн байна. Нэмэлт санхүүжилтээр 18.2 сая төгрөг хүлээн авчээ.

### 6.1.3 Үндсэн үйл ажиллагааны орлого

Толбо сумын төсөвт байгууллагуудад үндсэн үйл ажиллагаанаас 127.7 сая төгрөгийн орлого оруулах төлөвлөгөө өгөгдсөнөөс 100.0 сая төгрөгийн орлого оруулж, Сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөс төлөвлөсөн орлого бүрдээгүйгээс 27.7 сая төгрөгөөр дутуу гүйцэтгэлтэй байна.

### 6.1.4 Орон нутгийн татварын орлого

Толбо сумын ИТХ-аас сумын 2017 оны Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 62.3 сая төгрөгөөр баталжээ. Орлогын бүтцийг авч үзвэл нийт орлогын 15.2 хувийг ХАОАТатвараас, 84.6 хувийг бусад татвараас, 0.2 хувийг татварын бус орлогоос оруулахаар төлөвлөжээ.

Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал: /сая төгрөг/

Үзүүлэлт	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	хувь
<b>Нийт орлогын дүн</b>	<b>62,3</b>	<b>182,7</b>	<b>120,4</b>	<b>293,2</b>
<b>Татварын орлого</b>	<b>62,3</b>	<b>181,8</b>	<b>119,6</b>	<b>292,0</b>
ХАОАТатвар	9,5	10,3	0,8	108,9
Өмчийн татвар				
Бусад татвар	52,8	171,5	118,7	325,0
<b>Татварын бус орлого</b>		<b>0,8</b>	<b>0,8</b>	
<b>Б.ХӨРӨНГИЙН ОРЛОГО</b>	0,05	0	-0,05	0

Гүйцэтгэлээр Орон нутгийн орлогод нийтдээ 182.7 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, төлөвлөгөөг 120.4 сая төгрөгөөр буюу 293.2 хувиар давуулан

биелүүлжээ. Нийт орлогын 99.5 хувийг татварын орлогоос, 0,5 хувийг татварын бус орлогоос бүрдүүлжээ.

Орлогын нэр төрлөөр авч үзэхэд ХАОАТатварыг 0,8 сая төгрөгөөр буюу 1.1 дахин, бусад татварыг 118.7 сая төгрөгөөр буюу 3,3 дахин давуулан биелүүлжээ. Бусад татвараас агнуурын нөөц ашигласны төлбөрийн орлогоос 121.8 сая төгрөгийн орлогыг төлөвлөснөөс илүү оруулсан нь төлөвлөгөө нийт дүнгээр давж биелэгдэхэд гол нөлөө үзүүлжээ.

Орон нутгийн ерөнхий орлогын 910 тоот дансанд оны эхэнд 48.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба Орон нутгийн орлогын 995 тоот дансаар 460.5 сая төгрөгийн татварын орлого оруулж, оны эцэст орон нутгийн төсвийн ерөнхий орлогын 910 тоот дансанд 117.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

### **6.1.5 Бусад орлого**

Тайланд онд Орон нутгийн хөгжлийн санд 41.4 сая төгрөгийн санхүүжилт авч, Сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөс 99.8 сая төгрөгийн, Эргэлтийн эмийн санд 3.4 сая төгрөгийн, байгаль хамгаалах санд 0.1 сая төгрөгийн, мал хамгаалах санд 0.4 сая төгрөгийн орлого оруулсан байна.

## **6.2. Төсвийн зарлага санхүүжилтийн талаар:**

### **6.2.1 Төсвийн гүйцэтгэлийн талаар**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой төсөвт байгууллагуудын хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2017 оны урсгал зардалд нийтдээ 1952.9 сая төгрөгийн төсөв батлагдсаны 1384.5 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээр, 340.1 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 41.4 сая төгрөгийг ОНХСангаас, 127.7 сая төгрөгийг үйл ажиллагааны орлогоос, 59.1 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр тусгажээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээр 1384.5 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 343.2 сая төгрөгийн, ОНХСангаас 41.5 сая төгрөгийн санхүүжилтийг авч, үйл ажиллагааны орлогоос 100.0 сая төгрөг, урьд оны үлдэгдлээс 48.5 сая төгрөг бүрдүүлж бүгд дүнгээр 1917.8 сая төгрөгийн зарлага санхүүжилтээр ажиллаж, батлагдсан төсвөөс нийт дүнгээр 35.1 сая төгрөгөөр бага зарлага гаргажээ. Энэ нь Сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөс төлөвлөсөн орлого бүрдээгүй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.  
/сая төгрөг/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү /мөнгөн дүнгээр/	Зөрүү /Хувиар/
<b>1</b>	<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	<b>1952.9</b>	<b>1917.8</b>	<b>-35.1</b>	<b>98.2%</b>
1.1	Урсгал зардал	1952.9	1917.8	-35.1	98.2%
<b>2</b>	<b>Зардлыг сахүүжүүлэх эх үүсвэр</b>	<b>1952.9</b>	<b>1917.8</b>	<b>-35.1</b>	<b>98.2%</b>
2.1	Тусгай зориулалтын шилжүүлэг	1384.5	1384.5		
2.2	Орон нутгийн төсвөөс	340,1	343,2	3.1	
2.3	Орон нутгийн хөгжлийн сангаас	41.5	41.5		
2.4	Урьд оны үлдэгдлээс	59.1	48.5	-10.6	82%
2.5	Үндсэн үйл ажиллагааны орлогоос	127.7	100.0	-27.7	78.3

Төсвийн гүйцэтгэлийг байгууллага бүрээр харуулбал: /сая төгрөг/

Төсөвт байгууллагуудын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Сумын ИТХурал	51.9	51.9		100
Сумын ЗДТГазар	350.9	350.9		100
Бүрэн дунд сургууль	838.3	838.3		100
Эрүүл мэндийн төв	273.0	273.0		100
Хүүхдийн цэцэрлэг	221.4	221.4		100
Соёлын төв	52.8	51.7	1.1	97.9
СХСан	127.7	99.8	27.9	78.1
ОНХСан	31.4	22.1	9.3	70.4
БОХСан	5,5	8.7	-3,2	158.1
<b>Бүгд</b>	<b>1952.9</b>	<b>1917.8</b>	<b>35.1</b>	<b>98.2</b>

Сумын төсөвт байгууллагууд батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулсан байна.  
/сая төгрөг/

Үзүүлэлт	Тайлант оны		
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1952.8</b>	<b>1837.1</b>	
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1150.0	1147.6	2,3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	126,6	128,8	-2,2
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	77,4	76,1	1,2
Хангамж, бараа материалын зардал	32,8	34,9	-2,1
Нормативт зардал	121,7	120,1	1,8
Эд хогшил, урсгал засварын зардал	31,7	31,7	0
Томилолт, зочны зардал	4,8	4,7	0,1



Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	39,1	39,1	0
Бараа үйлчилгээний бусад зардал	150,0	61,0	89,0
Бусад урсгал шилжүүлэг	187,0	187,0	
Хөрөнгийн зарал	31,4	5,9	25,5

## 6.2.2 Нэмэлт санхүүжилтийн зарцуулалт

Тайлант хугацаанд Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийн дансаар нийтдээ 28.9 сая төгрөгийн орлого хүлээн авч урсгал зардалд 28.9 сая төгрөгийг зарцуулсан байна. Дээрх зардлыг санхүүжүүлсэн эх үүсвэрийг ангилал тус бүрээр нэмэлт төсвийн тайлангаар баримтжуулан баталгаажуулав.

## 6.2.3 Сангуудын зарцуулалт

Буянт сумын ОНХСан нь оны эхэнд 13,1 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба тайлант онд 241.4 сая төгрөгийн санхүүжилт авч, 22.1 сая төгрөгийг сумын ИТХурлаас батлагдсан төсөл арга хэмжээнд, 19.3 сая төгрөгийг мал эмнэлгийн үйлчилгээний зардалд зарцуулж, оны эцэст 29.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Сум хөгжүүлэх сангийн харилцах данс оны эхэнд 1,1 сая төгрөгийн үлдэгдэлтэй, тайлант онд эргэн төлөлтөөс 99,8 сая төгрөгийн орлогыг оруулж, тайлант онд 33.7 сая төгрөгийн зээл олгож, оны эцэст 67.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. СХСан нь жилийн эцэст 116.4 сая төгрөгийн зээлийн авлагатай байна.

Эргэлтийн эмийн сан харилцах данс оны эхэнд 0.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй, тайлант онд 3,4 сая төгрөгийн орлого оруулж, 1,4 сая төгрөгийг зарцуулж оны эцэст 0,02 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Байгаль хамгаалах сангийн харилцах данс оны эхэнд 8.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй бөгөөд тайлант онд 8.7 сая төгрөгийн орлого оруулж, 10.4 сая төгрөгийг зарцуулж, оны эцэст 6.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Мал хамгаалах сангийн харилцах дансанд оны эхэнд 1.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй, тайлант онд 0.4 сая төгрөгийн орлого оруулж, 1.7 сая төгрөгийг зарцуулжээ. Оны эцэст үлдэгдэлгүй гарсан байна.

## 6.3. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтийн талаарх тайлбар, тодруулга

### 6.3.1 Мөнгөн хөрөнгийн бүртгэл, тайлагнал

/сая төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт бууралт
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>73,2</b>	<b>220,5</b>	<b>147,3</b>
311	Кассанд байгаа бэлэн мөнгө			
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	73,2	110,5	37,3
3121	Төгрөг			

31211	Төрийн сангийн харилцах	62,9	220,5	157,6
31213	Арилжааны банк дахь харилцах	10,3		-10,3

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар оны эцэст нийтдээ 220.5 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй гарчээ. Мөнгөн хөрөнгийн бүтцийг авч үзвэл нийт үлдэгдэл мөнгөний 0,02 сая төгрөг нь арилжааны банкин дахь, 220.5 сая төгрөг нь төрийн сан дахь харилцах дансны үлдэгдэл байна.

Төрийн сан дахь харилцах дансны үлдэгдлийн 117.3 сая төгрөг нь Орон нутгийн ерөнхий орлогын, 67.3 сая төгрөг нь Сум хөгжүүлэх сангийн дансны үлдэгдэл, 29.4 сая төгрөг нь Орон нутгийн хөгжлийн сангийн, 6.5 сая төгрөг нь Байгаль хамгаалах сангийн дансны үлдэгдэл байна.

### 6.3.2 Авлагын бүртгэл, тайлагнал

/сая төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт бууралт
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>193,2</b>	<b>116,4</b>	<b>-76,8</b>
<b>335</b>	<b>Бусад авлага</b>			
33300	Татаас, санхүүжилтийн авлага	10,6		-10,6
3351	Байгууллагаас авах авлага			
3352	Хувь хүмүүсээс авах авлага			
<b>336</b>	<b>Зээлийн авлага</b>	<b>182,6</b>	<b>116,4</b>	<b>-66,2</b>
<b>3361</b>	<b>Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага</b>	<b>182,6</b>	<b>116,4</b>	<b>-66,2</b>
33612	Хувь хүмүүст олгосон зээл	182,6	116,4	-66,2

Санхүүгийн тайлан дахь авлагын үлдэгдэл өмнөх оноос 76.8 сая төгрөгөөр буурсан байна. Санхүүгийн албанаас сум хөгжүүлэх сангийн зээлийн авлагын өмнөх оны үлдэгдлийг харилцагч бүрээр тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, 66.2 сая төгрөгийн авлагыг барагдуулсан. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн авлага 10.6 сая төгрөгөөр буурсан байна. Сум хөгжүүлэх сангийн зээлийн авлагыг тооцоо нийлж, зээлдэгч нэг бүрээр гарын үсэг зуруулж үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.

### 6.3.3 Бараа материалын бүртгэл, тайлагнал

/сая төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт бууралт
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>88,5</b>	<b>70,2</b>	<b>-18,3</b>
351	Түүхий эд материал	8,4	7,1	-1,3
354	Хангамжийн материал	64,5	49,8	-14,7
356	Мал амьтад	15,6	13,4	-2,2

Оны эхэнд сумын хэмжээгээр 88.5 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй байсан бөгөөд 186.4 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч 6.4 сая төгрөгийг үнэ төлбөргүй хүлээн авч, 211.0 сая төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулжээ.

Бараа материалын үлдэгдэл оны эхнээс 18.3 сая төгрөгөөр буурсан байна. Бараа материалын бүтцийг авч үзвэл 10.1 хувь нь түүхий эд материал, 70.9 хувь нь хангамжийн материал, 19 хувь нь мал амьтад байна.

#### 6.3.4 Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагнал /сая төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт бууралт
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>5419,9</b>	<b>5476,5</b>	<b>56,6</b>
392	Биет хөрөнгө	5416,2	5472,8	56,6
393	Биет бус хөрөнгө	3,7	3,7	

Үндсэн хөрөнгө оны эхнээс 56.6 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант онд 25.6 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авч, 77.1 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авчээ. Төсөвт байгууллагууд нийтдээ 77.1 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авснаас ЗДТГазар нь 12.8 сая төгрөгийн, Бүрэн дунд сургууль 23.6 сая төгрөгийн, Эрүүл мэндийн төв 31.5 сая төгрөгийн, Соёлын төв нь 6.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг хөрөнгө оруулалтаар хүлээн авсан байна. Тайлант онд Эрүүл мэндийн төв нь 20.3 сая төгрөгийн хөрөнгийг акталж, данснаас хассан байна.

Тайлант онд үндсэн хөрөнгөнд 182.1 сая төгрөгийн элэгдэл тооцож, акталж данснаас хассан үндсэн хөрөнгийн элэгдэл 20.3 сая төгрөгийн элэгдлийн зардлыг бууруулсан байна.

#### 6.3.5 Өр төлбөрийн бүртгэл, тайлагнал /сая төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт бууралт
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>11,8</b>	<b>18,6</b>	<b>6,8</b>
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	11,8	18,6	6,8
413	Өглөг	11,8	18,6	6,8
4136	<b>Бусад өглөг</b>	11,8	18,6	6,8
41310	Ажилчидтай холбогдсон өглөг		4,3	4,3
41320	Бараа үйлчилгээний бусад өглөг	11,8	14,3	2,5

Оны эцэст ОНХСан 8,2 сая төгрөгийн, Эмийн эргэлтийн сан 2.2 сая төгрөгийн, Бүрэн дунд сургууль 6,8 сая төгрөгийн, Хүүхдийн цэцэрлэг 0.7 сая төгрөгийн, Эрүүл мэндийн төв 0.6 сая төгрөгийн, Соёлын төв 0.1 сая төгрөгийн өглөгтэй гарчээ.

#### 6.3.6 Цэвэр хөрөнгө/өмчийн талаар

Буянт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар цэвэр хөрөнгө өмчийн нийт дүн 3390.1 сая төгрөг буюу ЗГОКапитал 1860.5 сая төгрөг, дахин үнэлгээний нэмэгдэл 1274.1 сая төгрөг, хуримтлагдсан үр дүн 315.1 сая төгрөг байна. Тайлант онд -59.7 сая төгрөгийн үр дүнтэй ажиллаж, хуримтлагдсан үр дүн 315.1 сая төгрөг болж өссөн байна.

## **Долоо. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хангаж ажиллах зорилгоор [shilendans.gov.mn](http://shilendans.gov.mn) цахим хуудсанд 2017 оны мэдээлэлээ бүрэн байршуулжээ.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд 2017 онд хийсэн нийцлийн аудитаар Толбо сумын ТТЗ-ийн Шилэн дансны тухай хуулийн 6.4.5 дахь заалтыг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгуулах албан шаардлага өгсөн байна.

2017 оны 10-12 дугаар саруудын шилэн дансны мэдээллийг аудиторын зүгээс шалгаж Shilen dans-Buyant sumiin ТТЗ файлаар баримтжуулж, тайлантай хамт ажлын талбарт хавсаргав.

### **Найм. Аудитын дүнгийн талаар**

#### **8.1. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:**

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 11 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 38 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

#### **8.2. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар**

Буянт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний Орон нутгийн орлогын бүртгэл, тайлагнал, санхүүжилтийн эх үүсвэр, гүйцэтгэл, төсөвт байгууллага, сангуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг нэгтгэх, тулган баталгаажуулах зэргээр ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

#### **8.3. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар**

Санхүүгийн тайлангийн аудитаар материаллаг дараах алдаа зөрчил илрэв.

Үүнд:

1.Тайлант онд Байгаль хамгаалах санд 5.5 сая төгрөгийн санхүүжилт батлагдсан бөгөөд гүйцэтгэлээр 10.4 сая төгрөгийг зарцуулж, ямар нэгэн зөвшөөрөлгүй арилжааны банк дахь үлдэгдлийг 4.9 сая төгрөгөөр зарцуулсан байна. Сангийн сайд Монгол банкны ерөнхийлөгчийн хамтарсан 2013 оны 24/А-9 тушаалаар батлагдсан “Засгийн газрын болон төсвийн байгууллагын дансны Монголбанк, банкинд нээх, хаах журам”-ын 3.1-д “Дараах дансуудыг банкинд байршуулж болно”, 3.1.1 “төсвийн байгууллагын бэлэн мөнгөний үйлчилгээ үзүүлэх байгууллагын картын данс”, 3.1.6-д

“төсвийн байгууллагын ажилчдын цалин олгох харилцах данс” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: *Сумын Засаг даргад зөрчил арилгуулах албан шаардлага өгөө*

2. Аймгаас ЗДНХ-өөс 2.4 сая төгрөгийг, сумын давсан орлогоос 2.3 сая төгрөгийг тогтоол гарч хуваарилж өгсөн байна. Гэтэл сумын Засаг дарга 3.7 сая төгрөгийг захирамжгүй зарцуулсан байна. Сангийн сайдын 2012 оны 239 тушаалаар батлагдсан “ЗДНХөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 4 дэх заалтын 9-д “тухайн шатны ЗДТГазар төсвийн зардлын тооцоог Санхүү, төсвийн асуудал хариуцсан хэлтэс /тасаг/-ээр хянуулсан холбогдох газар, хэлтсээс санал авч, Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэний үндсэн дээр Засаг даргын захирамж гаргуулна” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна

Шийдвэрлэсэн нь: *Сумын Засаг даргад зөрчил арилгуулах албан шаардлага өгөө.*

3.Тайлант онд төрийн сан Бүрэн дунь сургуулиас 16900.0 мянган төгрөг, ЗДТГ-аас 7197.7 мянган төгрөгийг ТЕЗ, төрийн сангийн зохих зөвшөөрөлгүйгээр төсвийн зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан. Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т “батлагдсан төсвийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтанд нь хяналт тавих”, 42.5-д “Энэ хуулийн 15.2-т заасан төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн шууд захирагчийн төсөвт зохицуулалт хийх асуудлыг өөрийн баталсан төсвийн сар, улирлын хуваарьт өөрчлөлт оруулан шийдвэрлэнэ” 45.2-т “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэнд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухай шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ”

Шийдвэрлэсэн нь: *Сумын Засаг даргад зөрчил арилгуулах албан шаардлага өгөө.*

#### **8.4. Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар**

Аудитын явцад залруулагдаагүй алдаа зөрчил байхгүй.

#### **8.5. Анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

#### **8.6. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд**

Буянт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

### 8.7. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Буянт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй.

### 8.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

### 8.9. Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар

Буянт сумын Сумын ИТХурал, Соёлын төвийн санхүүгийн тайланд итгэл үзүүлж, Бүрэн дунд сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайлан, Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд бие даасан дүгнэлт гаргалаа.

Сумын Засаг даргын тамгын газар, ОНХСан, Сум хөгжүүлэх сан, Эргэлтийн эмийн сан, Мал хамгаалах сан, Байгаль хамгаалах сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн дүгнэлтэд оруулав.

Аудитын үр дүнг хүснэгтээр нэгтгэн харуулбал:

Төсвийн шууд захирагчийн нэр	Алдаа, зөрчлийн дүн /сая. төг/	Аудиторын санал дүгнэлт бүгд	Үүнээс			
			Зөрчилгүй санал дүгнэлт	Хязгаарлалттай санал дүгнэлт	Сөрөг санал дүгнэлт	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
Бүрэн дунд сургууль	20.8	1		1		
Эрүүл мэндийн		1	1			
Хүүхдийн цэцэрлэг		1	1			
Сумын ЗДТГазар	32.1					
ТТЗ-ийн СНТ	32.7	1	1			
<b>Дүн</b>	<b>53,0</b>	<b>4</b>	<b>3</b>	<b>1</b>		

### 8.10. Зөрчилгүй санал дүгнэлт

Буянт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан ... хуудас хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.ХУАНГАН  
Огноо:2018.03.25

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.ЖЕНИСБЕК  
Огноо:2018.03.25

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Ж.НАЗГҮЛ  
Огноо:2018.03.25